



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 1/20

Арвайхээр

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."л", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хил залгаа орших Булган, Дундговь, Төв аймгийн нутаг дэвсгэрт мал, амьтны гоц халдварт мялзан өвчин гахайнд илэрсэнтэй холбогдуулан урьдчилан сэргийлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч – И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)  
Гүшүүд: - О.Баярхагва (Тагнуулын ерөнхий газрын харъяа Өвөрхангай

аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа)  
(зөвшөрлцсөнөөр)

- С.Дуламсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн  
хяналтын газрын дарга)

- Д.Эрдэнэбат (Аймгийн Онцгой байдлын газрын дарга)

- О.Ганбат (Аймгийн Цагдаагийн газрын дарга)

- А.Нямдаваа (Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын үүргийг түр  
орлон гүйцэтгэгч)

-Д.Шиваанүрдэв (Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн  
газрын дарга)

-Г.Мөнхтөр (Аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт хэмжилзүйн  
хэлтсийн дарга)

-Ц.Ариунаа (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн  
газрын албаны дарга)

Нарийн бичгийн дарга –Н.Дулам (Аймгийн Засаг даргын Тамгын Газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн мэргэжилтэн)

2. Гоц халдварт мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч  
хэрэгжүүлэхийг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100053